


ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЕБ-ЫН ХАН-УУЛ СУРГУУЛИЙН 10-Р АНГИЙН  
НИЙГЭМ СУДЛАЛЫН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

Хугацаа: 80 минут

Хувилбар А

Нийт оноо 100

- .....нь хүн амын болон соёлын нөхөн үйлдвэрлэлээрээ өөрийн залгамж, тогтвортой чанарыг хангадаг, нэг нутаг дэвсгэр дээр амьдардаг, өөрийн зохион байгуулалт, эмх цэгц бүхий, улс төрийн хувьд биеэ даасан, өөрсдийгөө тухайн нийгэмд харьяалуулдаг хүмүүсийн тогтвортой нэгдэл юм. /2оноо/  
А. Нийгэм      Б.Бүлэг      В. Нийгмийн харилцаа      Г.Нийгмийн бүтэц
- Ахмад настай хүний нийгэмшилт хэрхэн явагддаг вэ? /2оноо/  
А. Нийгэмшилт хөгжих гэхээсээ бие, сэтгэхүйн чадамж буурсантайгаа зохицох, даван туулахад чиглэнэ.  
Б. Байр суурь, үүргийн хүлээлт нь тодорхойгүй тул бага өөрчлөгддөг  
В. Шинэ байр суурь, үүргийн шаардлага, хүлээлтийг хүлээн авах, туршлага хуримтлуулах  
Г. Зарим нь хүчтэй, залуу харагдахыг хичээж байхад нөгөө нийгэмд ийм зан төлөвийг шүүмжлэх зэргээр харилцан адилгүй зан үйлийг шаарддаг.  
Д. Бүгд зөв
- Нийгмийн институтийн чиг үүргийг судална гэдэг нь түүний гүйцэтгэж буй үүрэг буюу үйлдлийн үр дүнд ямар үр дагавар бий болов гэдгийг судлах хэрэг гэж уг онолын гол төлөөлөгч .....үзжээ. /2оноо/  
А. Дюркгейм      Б. К.Маркс      В. Ж.Г.Мид      Г. Р.Мертон      Д. Л.Толстой
- Нийгмийн хяналтын ангиллыг гүйцээнэ үү. /2оноо/



- А. Албан      Б. Албан бус      В. Албан, албан бус      Г. Амин

5. Дараах нийгмийн аргуудыг зөв харгалзуулна уу. /4оноо/

1. Асуулгын арга	А. Урьдчилан бэлтгэсэн асуулт хариулт бүхий хуудсаар, судалгааны олон нэгжээс нэг ижил горимоор мэдээлэл цуглуулах арга
2. Туршилт	Б. Сонирхож буй хувьсагч хоорондын хамаарлыг илрүүлэхээр зохиомол орчин бүрдүүлэх замаар судлах
3. Контент анализ	В. Баримт бичгээс тодорхой утгын нэгжийг хувьсагчаар сонгон, давтамж, хоорондын хамаарлыг статистик шинжилгээ ашиглан шинжлэх арга
4. Ганцаарчилсан ярилцлага	Г. Судалгаанд оролцогчоос асуулт асуух замаар мэдээлэл цуглуулах арга

- Хүний үйл ажиллагааны үр дүн болж, үеэс үед өвлөгддөг тэдгээр зүйлс, бас хүн олж эзэмшдэг мэдлэг, итгэл үнэмшил, ёс суртахуун, зан заншил болон бусад дадал чадварын нэгдэл нь .....юм. /2оноо/  
А. Нийгэмшил      Б. Соёл      В. Хүмүүжил      Г. Боловсрол      Д. Ёс заншил
- Миний дүү Бат аавын бүсээр шилбүүрдэн тоглож байгаад ээжид зэмлүүлэв. Үүнийг хараад, аав, дүү, бид 2т бүсээ дээдлэхийн утга учрын талаар ярьж

өглөө. “Монгол хүн бүсийг сүлд хийморь гэж үздэг. Тиймээс бүсээ дутуу бүслэн алдруулан, чирч явахыг цээрлэдэг, бүсээ чанга бүслэхийг төв чангын .....гэх ба бүсний үзүүрийг өмнө талдаа гарган ороож, нөгөө үзүүрийг мөн урдаа шингээж уяна. Бүсээ гутал өмдөн дээрээ тавих буюу бүсний дээгүүр алхах гишгэхийг цээрлэдэг. Бүс, малгайтай хүн бол хэн ч халдашгүй чөлөөт иргэн гэсэн утгыг илтгэдэг” хэмээн ярьсан юм. Цэгийн оронд тохирох утгыг нөхнө үү? /2оноо/

А. Мэдлэг    Б. Бэлгэдэл    В. Хэм хэмжээ    Г. Үнэлэмж    Д. Ёс заншил

8. Доорх соёлын түүхэн хэв маягаас аж ахуй эрхлэлтийг шалгуур болгосон ангилалд багтах төлөөллийг тодорхойлж хэлнэ үү ? /2оноо/

1. Ан агнуур    2. Түүвэрлэгчдийн соёл    3. Нүүдэлчдийн соёл

4. Газар тариаланчдын соёл    5. Өрнийн    6. Дорнын

А. 1,2,3,4    Б. 1,3,4,5    В. 1,2,4,6    Г. 1,6,5,2

9. Цэгийн оронд тохирох хариултыг тодорхойлж бичнэ үү? .....нь тухайн ард түмний түүх соёлыг хадгалан дамжуулах үндсэн арга хэрэгсэл юм. /2оноо/

А. Төрөлх хэл    Б. Техникийн хэл    В. Зохиомол хэл    Г. Философийн хэл

Д. Математикийн хэл

10. Соёлын чиг үүргийг жишээтэй нь зөв харгалзуулна уу. /4 оноо/

<p>А. Бэлгэдлийн чиг үүрэг</p> <p>Б. Үнэлэмж, хэм хэмжээний чиг үүрэг</p> <p>В. Нэгтгэн зохицуулах чиг үүрэг</p> <p>Г. Үйл ажилгааны чиг үүрэг</p>	<p>1. Сургуулийн хонх бол хичээл эхэлсэн, дууссаныг илтгэх тэмдэг</p> <p>2. Хүмүүс юуг сайн гэх, юуг зохисгүй гэж үзэхийг ялгах байдал</p> <p>3. Газар ус, өвөг дээдэс, ёс заншлаа дээдэлж ирсэн арга ухаан</p> <p>4. Үйлдвэрлэл, шинжлэх ухааны гэх мэт бүтээл туурвих үйл ажиллагаа</p>
--	---

11. Иргэний эрх зүйн харилцааны бүрдэл хэсгүүдэд хамаарах өгөгдлийг олно уу? /2оноо/

А. Объект

Б. Субъект

В. Агуулга

Г. а b хариулт зөв

Д. а b c хариулт зөв

12. Монгол улсын Үндсэн хуулинд заасан иргэний үндсэн үүргийг нэрлэхдээ илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? /2оноо/

А. Татвар төлөх

Б. Эх орноо хамгаалах, эр цэргийн алба хаах

В. Хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх

Г. Байгаль орчноо хамгаалах

Д. Үндсэн хууль болон бусад хуулийг биелүүлэх

13. Захиргааны тухай хуулиар зөрчил гаргасан этгээдэд дараах шийтгэлийг оногдуулна. /2оноо/

Торгох

.....

Тусгайлан олгосон эрх хасах

А. Баривчлах


Б. Сануулах

В. Торгох

Г. Торгуулах

Д. Мэдэхгүй

14. Нийгмийн хамгааллын эрх зүйн харилцааны төрлүүдийг нэрлэнэ үү. /2оноо/



А. Нийгмийн даатгал

Б. Нийгмийн халамж

В. Тэтгэвэр

Г. Тэтгэмж

15. Иргэн А худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаагаа явуулдаг С компанид нягтлан бодогчийн ажилд 2016 оны 02 сарын 01-нд туршилтын 6 сарын хугацаатай ажиллахаар хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилд орсон. Ажил олгогчоос А 2016 оны 09 сарын 08-нд гэрээний хугацаа дууссан гэсэн

үндэслэлээр ажлаас халсан байна. Эх сурвалж: БСШУЯ Хөдөлмөрийн эрх зүй хичээлийн зохиомж. УБ 2015 он.

Асуулт А. Хэний хооронд ямар асуудал үүссэнийг тайлбарлаарай. /2оноо/

А. Иргэн А, С компанид хооронд хөдөлмөрийн харилцааны асуудал

Б. Дээд албан тушаалтанд хандан амаар болон бичгээр гомдол гаргаж эвлэрэх, шүүхэд хандах

В. Иргэний хуулиар шийдүүлэх

Г. Хоорондоо тохиролцоно

16. Хүний эрхийн суурь зарчмуудыг зөв тохируулаарай /4 оноо/

1	Тэгш байдлыг хангах	А	Хүний эрх нь орон гэр, сургууль, ажлын байр, зах зэрэг газар бүрт, амьдралын бүхий л хүрээг хамардаг, өөрөө хэлбэл аль нэг эрх нь зөрчигдөхөд бусад эрхүүдэд нөлөөлнө, нөгөө талаар нэг төрлийн эрхийг хангах явдал сайжрахад өөр эрхийг эдлэх боломж илүү бүрддэг.
2	Хуваагдашгүй байх	В	Арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улстөрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал, өмч хөрөнгө, төрсөн байдал болон нийгэмд эзэлж байгаа байр сууриас үлй хамаран хэнийг ч ялгаварлан гадуурхаж болохгүй.
3	Харилцан хамааралтай байх	С	Хүн болж төрснийхөө хувьд хүн бүр ижил үнэ цэнэтэй байж, адил хүндэтгэлийг эдэлнэ.
4	Ялгаварлан гадуурхахгүй байх	Д	Иргэний, улс төрийн, нийгэм эдийн засаг, соёлын болон хамтын эрх зэрэг хүний бүх эрхүүд нэгдмэл хуваагдашгүй байдаг.

17. Зөв харгалзуулна уу. /4оноо/

1. Гомдол	А. Захиргааны байгууллагын буруугаас иргэн, хуулийн этгээдийн эрх нь зөрчигдөж, зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр гаргасан хүсэлт
2. Өргөдөл	Б. Тодорхой ажиллагааг эхлүүлэх, эсвэл дуусгавар болгох тухай захиргааны байгууллагад гаргасан хүсэлт
3. Хүсэлт	В. Өөрт болон бусдад тулгарч буй асуудлыг шийдвэрлүүлэх тухай захиргааны байгууллагад хандаж буй баримт
4. Акт	Г. Нийтийн ашиг сонирхолыг хамгаалах зорилгоор хамгаалах зорилгоор захиргааны байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэр юм.

18. Тухайн улсын хэмжээгээр нэг жилийн хугацаанд үйлдвэрлэсэн, эцсийн бараа, үйлчилгээний зах зээлийн үнийн дүнг .....гэнэ. /2оноо/

А. Дотоодын нийт бүтээгдэхүүн

Б. Үндэсний нийт бүтээгдэхүүн

В. Нэрлэсэн Дотоодын нийт бүтээгдэхүүн

Г. Үндэсний цэвэр орлого

Д. Тохирох өгөгдөл алга

19. Дэлхийн эдийн засгийн их хямралын үе 1933 онд ажилчид олноороо ажлаас халагдах тохиолдол үүсч, АНУ-д ажилгүйдэл 25%-д хүрч байсан. Энэ нь: /2оноо/

А. Байнгын ажилгүйдэл

Б. Мөчлөгийн ажилгүйдэл

В. Улирлын ажилгүйдэл

Г. Шилжилтийн ажилгүйдэл

Д. Бүтэцийн ажилгүйдэл

20. ДНБ-ийг орлогоор тооцох аргыг тодорхойлохдоо илүүц зүйл оруулсан бол аль нь вэ? /2оноо/

А. Цалингийн орлого

Б. Төрийн зардал

В. ААН-ийн ашиг

Г. Түрээсийн орлого

Д. Шууд бус татварын орлого

21. Дараах бүдүүвчийг гүйцээнэ үү. /2оноо/



А. 1. Хилийн чанад дахь Монгол улсын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөг. 2. Монгол дахь гадаадын хөрөнгө оруулалттай ААН-ийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөг

Б. 1. Тухайн улсын хэмжээгээр нэг жилийн хугацаанд үйлдвэрлэсэн, эцсийн бараа, үйлчилгээний зах зээлийн үнэ. 2. Хилийн чанад дахь Монгол улсын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөг

В. 1. Өрх гэийн хэрэглээний зардал. 2. Төрийн зардал

Г. 1. Гадаад хэрэглэгчийн зардал. 2. Монгол дахь гадаадын хөрөнгө оруулалттай ААН-ийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөг

22.Цэгийн оронд тохирох өгөгдлийг бичнэ үү. .... нь тоон үзүүлэлт, тэдгээрийн харьцааг шугам, геометрийн дүрс, зураг эсвэл газарзүйн картын тусламжтайгаар илэрхийлэх арга юм. /2оноо/

А. Венийн диаграмм    Б. График    В. Хүснэгт    Г. Анализ    Д. Синтез

23. Дотоодын нийт бүтээгдэхүүний зардлаар тооцдог аргуудыг тайлбартай нь зөв харгалзуулна уу. /4оноо/

1	Өрх гэрийн хэрэглээний зардал	А	ААН-үүдийн хөрөнгө оруулалтын зардал
2	Аж ахуй нэгжийн зардал	В	Өрх гэрийн хэрэглээндээ зориулан хүнс, бараа болон үйлчилгээ худалдан авахад зарцуулсан зардал
3	Төрийн зардал	С	Гадаадын иргэдээс манай бараа, үйлчилгээг худалдан авахад зарцуулсан зардал
4	Гадаад хэрэглэгчийн зардал	Д	Төрөөс төрийн албан хаагчдад зориулан бараа, үйлчилгээг худалдан авах, сургууль, эмнэлэг, зам зэргийг барихад гаргасан зардал

24. Утгаар нь зөв харгалзуулна уу. /4оноо/

- |                         |   |
|-------------------------|---|
| 1. Мөчлөгийн ажилгүйдэл | a. Эдийн засгийн уналтын үед бий болдог |
| 2. Улирлын ажилгүйдэл   | b. Цаг улирлын байдалтай холбоотой      |
| 3. Шилжилтийн ажилгүйд  | c. Шинэ салбар мэргэжлийн шаардлага     |
| 4. Бүтцийн ажилгүйдэл   | d. Нэг ажлаас нөгөө ажилд шилжих        |

25. . “Ардчилал нь ард түмнээс сонгогдсон, ард түмний төлөө, ард түмний өөрсдийнх нь засаглал юм” гэж хэн хэлсэн бэ? /2оноо/

А. У.Черчилль    Б. Т.Жефферсон    В. К.Поппер    Г. Ж.Локк    Д. А.Линкольн

26. Монгол улсын “Шинэ үндсэн хууль” хэдэн онд батлагдсан бэ? /2оноо/

А. 1924.11.26    Б. 1940.06.30    В. 1960.11.30    Г. 1992.07.27    Д.

1992.01.13

27. Ардчилсан нийгэм нь иргэдийн эрхийг хамгаалах, үйлчлэх анхдагч үүргээ сонгуульт албан тушаалтан, төрийн албан хаагчдын эрх мэдлээ урвуулан, хэтрүүлэн ашиглах явдлаас урьдчилан сэргийлэх боломжийг олгодог. Энэ нь ардчиллын ямар үнэт зүйлсэд хамаарах ойлголт вэ? /2оноо/

- А. Эрх мэдлээ хэтрүүлэхэд хяналт тавих  
 Б. Хуулийн засаглал  
 В. Нийтэд тайлагнах, ил тод байх ёс  
 Г. Тогтмол, чөлөөт шударга сонгууль  
 Д. Боловсрол

28. Манай улсад гүйцэтгэх эрх мэдлийг ямар байгууллага хэрэгжүүлдэг вэ? /2оноо/

- А. Улсын дээд шүүх  
 Б. Ерөнхийлөгч  
 В. Засгийн газар  
 Г. Улсын Их Хурал  
 Д. Үндсэн Хуулийн Цэц

29. Ардчилсан нийгэмд ..... нь иргэддээ үйлчлэх гол үүрэгтэй ба энэ үйлчилгээ ..... шаардлагад нийцэхгүй байх нь авилга дэлгэрэх гол нөхцөл болдог. /2оноо/

А. Худал, үзүүлэх боломж      Б. Улс, улс төр      В. Төр, ил тод      Г. Төр, улс төр

30. Шууд ..... нь олон түмэн өөрөө өөрийгөө ..... хэлбэр. /2оноо/

А. Ардчилал      Б. Удирдах      В. Ардчилал, илэрхийлэх      Г. Ардчилал, удирдах

31. Төрийн эрх мэдлийн хуваарилалтын тогтолцоог зөв нэрлэнэ үү. /4оноо/

1. Хууль тогтоох эрх мэдэл	А. Монгол улсын ерөнхийлөгч , Засгийн газар
2. Шүүх эрх мэдэл	Б. Үндсэн хуулийн цэц
3. Гүйцэтгэх эрх мэдэл	В. Улсын дээд шүүх
4. Үндсэн хуулийн цэц	Г. Улсын их хурал

32. Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу. /4оноо/

А. Хүний эрх, эрх чөлөө	1. Хүн бүр эрх тэгш, чөлөөтэй байх эрхтэй, эрхэм зэрэгтэй төрсөн
Б. Иргэдийн улс төрийн оролцоо	2. Иргэд төрийн хэрэгт оролцох нь тэдний эрх төдийгүй иргэнийхээ хувьд хүлээж байгаа ёс суртахууны үүрэг юм.
В. Тэгш эрх	3. Ямар ч иргэнийг ижил боломжтой байлгаж, арьс өнгө, шашин шүтлэг, үндэс угсаа, хүйс үзэл бодлоор ялгаварлахгүй байхыг хэлнэ.
Г. Нийтэд тайлагнах, ил тод байх ёс	4. Ардчилсан нийгэмд сонгогдсон болон томилогдсон албан тушаалтан ард олонд тайлангаа тавих үүрэгтэй.

33. Олон улсын харилцааны үндсэн гол оролцогч аль нь вэ? /2оноо/

А. Олон улсын байгууллагууд      Б. Улс бус оролцогчид  
В. Бүрэн эрхт тусгаар тогтносон улс      Г. Үндэстэн дамнасан байгууллагууд  
Д. Нөлөө бүхий хувь хүмүүс

34. Өөрийн ойрын хүрээлэлдээ ялангуяа хөрш улсууд, бүс нутагтаа баттай нөлөөлдөг, голчлон тогтвортой эдийн засгийн хөгжилтэй улсыг олон улсын харилцааны “улс” оролцогчийн аль ангилалд хамруулдаг вэ? /2оноо/

А. Хөрш орон      Б. Их гүрэн      В. Бага улс      Г. Дунд улс      Д. Хаант улс


35. Монгол улсын гавьяат тамирчин М.Бундмаа, ОУХМ Б.Батгэрэл нар Хонгконгийнэ шигшээ багийн урилгаар тус хотод ажиллажээ. НҮБ-ын энхтайвны элч Малала Юсуфзай охин 11 настайгаасаа эхлэн террористуудын эсрэг тэмцэж, Пакистаны охидын эрхийг хамгаалахын төлөө тэмцэж байна. М.Бундмаа, Малала нар олон улсын харилцаанд хэрхэн оролцож байна вэ? /2оноо/

А. Олон улсын харилцааны иргэн оролцогч      Б. ОУХ-ны улс оролцогч  
В. ОУХ-ны улс бус оролцогч      Г. Аль нь ч биш

36. Де-юре гэдэг олон улсын хэллэг нь ямар утгыг илэрхийлдэг вэ? /2оноо/

А. Соёл урлагийн ойлголтоор тухайн улсыг хүлээн зөвшөөрсөн хэлбэр  
Б. Эрх зүйн ойлголтоор тухайн улсыг бүрэн бус хүлээн зөвшөөрсөн хэлбэр  
В. Ёс зүйн ойлголтоор тухайн улсыг бүрэн бус хүлээн зөвшөөрсөн хэлбэр  
Г. Ёс зүйн ойлголтоор тухайн улсыг бүрэн хүлээн зөвшөөрсөн хэлбэр  
Д. Эрх зүйн ойлголтоор тухайн улсыг бүрэн хүлээн зөвшөөрсөн хэлбэр

37. Загварыг гүйцээн бичнэ үү. /2оноо/



А. Дунд улс      Б. Бага улс      В. Дунд улс, Бага улс      Г. Их гүрэн, Бага гүрэн

38. Улс оролцогчийг ....., ..... гэх хоёр хэлбэрээр хүлээн зөвшөөрдөг.  
/2оноо/

А. Де-факто                      Б. Улс, Улс бус                      В. Де-юре, Де-факто                      Г. Де-юре

39. Олон улсын харилцаанд оролцох үүрэг, үйл ажиллагааны чиглэлийг зөв тохируулна уу. /4оноо/

1. ОУХ-нд оролцох үүрэг	А.Монгол улс бусад улсын улстөр, эдийн засаг, соёлын хүч чадавх, үйл ажиллагааг өөрийн боломжоор хянах, үнэлэх, явдал
2. ОУХ-д оролцох үйл ажиллагааны чиглэл	Б. ОУХ-нд улстөр, эдийн засаг, эрхзүй, худалдаа ШУ, хүмүүнлэгийн гэсэн үйл ажиллагааны чиглэлээр оролцдог
3. ОУХ-нд оролцох нөлөө	В.Олон улсын улстөр, эрхзүй, эдийн засаг, соёлын зэрэг олон талт харилцаанд гадаад бодлогоороо дамжуулан оролцох үйл ажиллагааны цар хүрээ, нөлөөллөөр тодорхойлогдоно
4.Олон улсын харилцаа	Г. Дэлхийн улс ба улс бус оролцогчид хоорондын олон талт харилцаа, тэдний гадаад бодлого, үйл ажиллагааг судалдаг нийгмийн шинжлэх ухааны салбар юм.

40. Зөв харгалзуулна уу./4оноо/

1	Гаалийн эдийн засгийн зорилго	А	Монгол улсын тусгаар тогтнол, аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл орчин, хүнсний аюулгүй байдлыг хангах, нийгэм, соёлын үнэт зүйлийг хамгаалах, хар тамхи, мансууруулах бодисыг хилээр нэвтрүүлэхгүй байх
2	Гаалийн эрх зүйн хамгаалалтын зорилго	Б	Гаалийн татвар хураамжийг авч төрийн төсвийн орлогыг бүрдүүлэх
3	Гаалийн зохицуулалтын зорилго	В	Хилээр бараа, гаалийн тээврийн хэрэгсэл нэвтрүүлэхэд татвар тогтоох, оруулах гаргах харилцааг хэрэгжүүлэх
4	Гаалийн үйл ажиллагааны зорилго	Г	Эдийн засгийн, зохицуулалтын гаалийн

Агуулга	А хувилбар
Нийгэм, нийгмийн харилцаа	1А
	2Д
	3Г
	41А2Б3Г4В
	5. 1А2Б3В4Г
Соёл	6Б
	7Б
	8А
	9А
	10. 1А2Б3В4Г
Эрх зүй	11Д
	12Г
	13А
	14А
	15А
	16. 1В2Г3А4Б
	17. 1А2Б3В4Г
Эдийн засаг	18А
	19Б
	20Д
	21А
	22А
	23. 1Б2А3Г4В
	24А
Улс төр	25Д
	26Д
	27А
	28В
	29В
	30Г
	31.1Г2Б3А4В
	32.1А2Б3В4Г
Олон улсын харилцаа	33В
	34Г
	35А
	36Д
	37В
	38В
	39.1В2Б3А4Г
	40.1Б2А3В4Г

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЕБ-ЫН ХАН-УУЛ СУРГУУЛИЙН 10-Р АНГИЙН  
НИЙГЭМ СУДЛАЛЫН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

Хугацаа: 80 минут

Хувилбар Б

Нийт оноо 100

1. Нийгэмшилтийн агент гэж юу вэ? /2оноо/

- А. Байгууллага, хувь хүн, бүлэг  
Б. Нийгмийн тодорхой нөхцлүүдийн цогц, хувь хүн, бүлэг, байгууллага  
В. Хувь хүн, бүлэг, гэр бүл, сургууль  
Г. Нийгмийн тодорхой нөхцөл, сургууль, хэвлэл мэдээлэл

2. Дараах өгөгдлөөс нийгмийн гажуудалд хамаарахыг олно уу. /2оноо/

- А. Гэмт хэрэг Б. Сэтгэцийн өвчин В. Архидалт  
Г. Биеэ үнэлэлт Д. Дээрх бүгд зөв

3. Чиг үүргийн хэлбэрүүдийг гүйцээнэ үү. /2оноо/

Ил чиг үүрэг



- А. Далд Б. Сөрөг В. Далд, эерэг Г. Далд, сөрөг

4. Нэг хүний үүргүүд нь нөгөөгийн хэрэгжилтэд саад учруулах зэргээр зөрчигддөг бөгөөд үүнийг ... гэнэ. /2оноо/

- А. Үүргийн мөргөлдөөн В. Үүргийн зөрчил  
С. Үүргийн тасалдал Д. Бүгд зөв

5. Дараах өгөгдлийг зөв харгалзуулаарай /4оноо/

А. Нийгэмшилт

1. Хүн нийгмийн харилцаанд бие даан оролцох, нийгмийн үйлдлүүдийг хийх чадварыг эзэмших, нийгмээс хүлээж буй шаардлагыг биелүүлэх чадамж бүхий болон төлөвших үйл явц

Б. Адилсал  
нийгэмд

2. Хувь хүн өөрийгөө нийгмийн тодорхой бүлэг, нийтлэг,

харьяалуулан, тэрхүү бүлэг, нийтлэг, нийгмээ илэрхийлэгч онцлог шинжийг нь тээгч болох үйл явц

В. Нийгмийн гажуудал

3. Нийгэм, нийгмийн бүлгийн олонх гишүүдийн хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, хүлээлттэй үл нийцэх төлөв

Г. Нийгмийн хяналт  
нийгмийн

4. Гажуудлаас урьдчилан сэргийлэх, арилгах үүднээс

гишүүдийн зүгээс гажуудагчийг шийтгэх, засан хүмүүжүүлэх зэрэг хэлбэрээр авч буй арга хэмжээ буюу санкциудын цогц.

6. Сайн үйл, шударга ёс, эрх чөлөөг аль ч ард түмэн эрхэмлэдэг. Энэ нь: /2оноо/

- А. Хэл Б. Мэдлэг В. Үнэлэмж Г. Хэм хэмжээ Д. Тэмдгийн тогтолцоо

7. Сургуулийн хонх бол хичээл эхэлсэн дууссаныг илтгэх тэмдэг, Ард Аюушийн хөшөө бол эх оронч байдлын бэлгэ тэмдэг болдог. Энэ нь: /2оноо/

- А. Бэлгэдлийн чиг үүрэг Б. Үнэлэмж, хэм хэмжээний чиг  
В. Нэгтгэн, зохицуулах чиг үүрэг Г. Үйл ажиллагааны чиг үүрэг  
Д. Илүүц зүйл алга

8. Доорх соёлын хэв маягийг түүхэн дарааллаар нь байршуулна уу. /2оноо/

1. Эртний 2. Хүй нэгдлийн 3. Дундад зууны 4. Сэргэн мандалтын  
5. Шинэ үеийн 6. Орчин үеийн

- А. 1,3,2,4,6,5 Б. 1,3,2,4,5,6 В. 2,1,3,4,5,6 Г. 2,1,3,4,6,5

9. “Зөгий, шоргоолжны эд эсэнд нь шингэсэн үйлдэл хийх чадвар байдаг шиг хүнд төрөлхөөс заяадаггүй, ахмад үеэсээ залуу үе нь зориуд сурч мэдэж, өвлөх ёстой үйлдэл хийх чадвар байдгийг соёл гэж тэмдэглэсэн” эрдэмтэн аль нь вэ? /2оноо/



А. А.Гидденс                      Б. Р.Бенедикт                      В. Эдуард Тайлор  
Г. Эрнст Кассирер                      Д. Ж.Мёрдок

10. Дараах өгөгдлийг зөв харгалзуулаарай. /4оноо/

- А. Үнэлэмж                      1. Нийт хүн төрөлхтөний хувьд хүлээн зөвшөөрөгддөг утгат чанарууд.
- Б. Үнэлэмжийн баримжаа                      2. Үнэлэмжийг хувь хүн өөриймшүүлсэн хэр хэмжээ, түвшин.
- В. Үнэлгээ                      3. Нийгмийн бүлэг, хамт олон, бие хүний зан төлөв, үйлдлийг тодорхой шалгуурт нийцэж байна уу, үгүй юу гэдгийг шүүн тунгаах үйл явц.

11. Хүний эрхэм чанарын үндсэн шинжид аль нь хамаарах вэ? /2оноо/

- А. Хүний эрхэм чанар тухайн хүнээс өөрөөс нь шалтгаална.  
Б. Хүний эрхэм чанар нь хүн бүрд харилцан адилгүй байна.  
В. Хүний эрхэм чанар нь хэмжигдэх үнэт зүйл  
Г. Хүний эрхэм чанарыг хүнээс салгаж үл болно.  
Д. Хүний эрхэм чанарт хэн нэгэн нөлөөлж чадна.

12. Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх ямар тохиолдолд үүсэх вэ? /2оноо/

- А. Нийгмийн даатгалын шимтгэлийг 12 сар, түүний сүүлийн 6 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд  
Б. Нийгмийн даатгалын шимтгэлийг 24 сар, түүний сүүлийн 12 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд  
В. Нийгмийн даатгалын шимтгэлийг 6 сар, түүний сүүлийн 3 сард нь тасралтгүй төлсөн нөхцөлд  
Г. Нийгмийн даатгалын шимтгэлийг тасралтгүй 3 жил төлсөн тохиолдолд

13. Захиргааны тухай хуулиар зөрчил гаргасан этгээдэд дараах шийтгэлийг оногдуулна /2оноо/

1. ....

2. Баривчлах

3.Тусгайлан олгосон эрх хасах

А. Баривчлах

Б. Сануулах

В. Торгох

Г. Торгуулах

14. Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан хүний эрхийн суурь зарчмуудыг гүйцээнэ үү. /2оноо/

1. Тэгш байдлыг хангах

2. ....

3. Түгээмэл салшгүй байх

4. Хүн үнэ цэнэ нэр төртэй байх

А. Хүний эрх

Б. Үнэ цэнэтэй байх

В. Ялгаварлан гадуурхахгүй байх

Г. Мэдэхгүй

15. Хариуцлага тооцох хэлбэрүүдийг гүйцээнэ үү. /2оноо/

Төртэй хариуцлага тооцох

А. Төртэй хариуцлага тооцох

Б. Бусад этгээдтэй хариуцлага тооцох

В. Хувь хүнтэй хариуцлага тооцох

Г. Боловсролын байгууллага

Д. Төрийн байгууллага

16. . Дараах өгөгдлийг зөв харгалзуулна уу. /4оноо/

- А. Хүний эрхэм чанар                      1. Хүн бүр хаана, хэн болон төрж, хэрхэн амьдарч байгаагаас үл хамаарч хүмүүн болохынхоо хувьд адилхан үнэ цэнэтэй, эрх тэгш байх тухай ойлголт юм.
- Б. Хүний эрх                      2. Хүнийг төрж мэндэлсэн цагаас хамт бий болдог бөгөөд хүйсийн байдал, угсаа гарвал, итгэл

- үнэмшлээс үл хамааран адил тэгш эдлэгдэх эрхүүд юм.
- В. Үндсэн хуулийн суурь зарчим 3. Үндсэн хуулиар тодорхойлогдсон төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим.
- Г. Эрх зүйд захирагдах ёс 4. Бүх нийтээр хүлээн зөвшөөрсөн Үндсэн хууль болон бусад хууль тогтоомж нь хүн бүрт тэгш үйлчлэх явдал юм.

17. . Хүний эрхийн суурь зарчмуудыг зөв тохируулаарай. /4оноо/

1	Тэгш байдлыг хангах	A	Хүний эрх нь орон гэр, сургууль, ажлын байр, зах зэрэг газар бүрт, амьдралын бүхий л хүрээг хамардаг, өөрөө хэлбэл аль нэг эрх нь зөрчигдөхөд бусад эрхүүдэд нөлөөлнө, нөгөө талаар нэг төрлийн эрхийг хангах явдал сайжрахад өөр эрхийг эдлэх боломж илүү бүрддэг.
2	Хуваагдашгүй байх	B	Арьс өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улстөрийн болон бусад үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарал, өмч хөрөнгө, төрсөн байдал болон нийгэмд эзэлж байгаа байр сууриас үл хамааран хэнийг ч ялгаварлан гадуурхаж болохгүй.
3	Харилцан хамааралтай байх	C	Хүн болж төрснийхөө хувьд хүн бүр ижил үнэ цэнэтэй байж, адил хүндэтгэлийг эдэлнэ.
4	Ялгаварлан гадуурхахгүй байх	D	Иргэний, улс төрийн, нийгэм эдийн засаг, соёлын болон хамтын эрх зэрэг хүний бүх эрхүүд нэгдмэл хуваагдашгүй байдаг.

18. Улирлын үйл ажиллагаатай холбоотой үүсэн түр ажилгүйдлийн хэлбэрийг .....гэнэ. /2оноо/

- А. Байнгын ажилгүйдэл
- Б. Мөчлөгийн ажилгүйдэл
- В. Улирлын ажилгүйдэл
- Г. Шилжилтийн ажилгүйдэл
- Д. Бүтцийн ажилгүйдэл

19. Хэрэглэгчдийн эцсийн хэрэглээндээ зориулан худалдан авахад зарцуулсан бүтээгдэхүүн, үйлчилгээний зардлын нийлбэр дүнгээр дотоодын нийт бүтээгдэхүүнийг тодорхойлох аргыг .....гэнэ. /2оноо/


- А. Зардлаар тооцох арга
- Б. Орлогоор тооцох арга
- В. Нэг хүнд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн
- Г. Нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүн

Д. Зардал

20. “Үлээх”, “хөөрөгдөх” гэсэн утгатай латин гаралтай үг бөгөөд эдийн засагт бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ ерөнхийдөө өсөж хүн амын худалдан авах чадвар буурах үзэгдлийг юу гэж нэрлэдэг вэ? /2оноо/

- А. Дефляци
- Б. Инфляци
- В. Үнийн өсөлт
- Г. Хэрэглээний сагс
- Д. Хэрэглээний үнийн индекс

21. Дараах бүдүүвчийг гүйцээнэ үү. /2оноо/



- А. 1. Хилийн чанад дахь Монгол улсын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөг. 2. Монгол дахь гадаадын хөрөнгө оруулалттай ААН-ийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөг
- Б. 1. Тухайн улсын хэмжээгээр нэг жилийн хугацаанд үйлдвэрлэсэн, эцсийн бараа, үйлчилгээний зах зээлийн үнэ. 2. Хилийн чанад дахь Монгол улсын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөг
- В. 1. Эрх гэийн хэрэглээний зардал. 2. Төрийн зардал

Г. 1. Гадаад хэрэглэгчийн зардал. 2. Монгол дахь гадаадын хөрөнгө оруулалттай ААН-ийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний өртөг

21. Соёлын чиг үүргийг жишээтэй нь зөв харгалзуулна уу. /4 оноо/

А. Бэлгэдлийн чиг үүрэг	1. Сургуулийн хонх бол хичээл эхэлсэн, дууссаныг илтгэх тэмдэг
Б. Үнэлэмж, хэм хэмжээний чиг үүрэг	2. Хүмүүс юуг сайн гэх, юуг зохисгүй гэж үзэхийг ялгах байдал
В. Нэгтгэн зохицуулах чиг үүрэг	3. Газар ус, өвөг дээдэс, ёс заншлаа дээдэлж ирсэн арга ухаан
Г. Үйл ажилгааны чиг үүрэг	4. Үйлдвэрлэл, шинжлэх ухааны гэх мэт бүтээл туурвих үйл ажиллагаа

22. ХХ зууны эхээр гүйлгээнд байгаа мөнгөний тоо хэмжээ нь бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн түвшинд нөлөөлдөг болохыг судлан гүйлгээнд байгаа мөнгөний хэмжээ хэдий их байна, бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ төдийн чинээ өндөр болдгийг тогтоосон эдийн засагч хэн бэ? /2оноо/

А. Фридман      Б. Кейнс      В. Фишер      Г. Оукен      Д. Лаффер

23. Доорх өгөгдлийг зөв харгалзуулаарай. /4оноо/

- |                             |                                   |
|-----------------------------|-----------------------------------|
| 1. Цалин                    | а. Газрын эздийн орлого           |
| 2. Зээлийн хүү              | б. Капиталын орлого               |
| 3. Түрээсийн төлбөр         | с. Аж ахуйн нэгжийн эздийн орлого |
| 4. Ашиг                     | д. Ажиллагчдын орлого             |
| 5. Үндсэн хөрөнгийн элэгдэл | е. Мөнгө зээлдүүлэгчдийн орлого   |

24. Утгаар нь зөв харгалзуулаарай. /4оноо/

- |                          |   |
|--------------------------|---|
| 1. Мөчлөгийн ажилгүйдэл  | а. Эдийн засгийн уналтын үед бий болдог |
| 2. Улирлын ажилгүйдэл    | б. Цаг улирлын байдалтай холбоотой      |
| 3. Шилжилтийн ажилгүйдэл | с. Шинэ салбар мэргэжлийн шаардлага     |
| 4. Бүтцийн ажилгүйдэл    | д. Нэг ажлаас нөгөө ажилд шилжих        |

25. Төрийн эрх мэдлийг хуваарилах Ш.Монтескьегийн онол аль нь вэ? /2оноо/

А. Хуулийг хэрэгжүүлэх, хууль сахиулах      Б. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх  
В. Хууль тогтоох, хууль сахиулах, шүүх      Г. Хууль тогтоох, шүүх, прокурор  
Д. Хууль боловсруулах, гүйцэтгэх, шүүх

26. Монгол улс засаглалын ямар хэлбэртэй вэ? /2оноо/

А. Ерөнхийлөгчийн засаглал      Б. Холимог засаглал      В. Парламентын засаглал  
Г. Үндсэн хуульт засаглал      Д. Ардчилсан засаглал

27. Ардчилсан нийгэмд бүх иргэдэд адил тэнцүү боломж олгодог зарчим аль нь вэ? /2оноо/

А. Нээлттэй байх зарчим      Б. Шударга байх  
В. Хууль дээдлэх      Г. Цөөнхийг хүндэтгэх зарчим

28. ....засаглалын эрх мэдлийг хуваарилах, хүний эрхийг баталгаажуулах, улс орны суурь гол харилцааг зохицуулах үүрэгтэй хамгийн дээд чадалтай засаг төрийн гол хууль мөн. /2оноо/

А. Боловсролын хууль      Б. Хөдөлмөрийн хууль  
В. Төрийн хууль      В. Үндсэн хууль      Г. Монгол улсын хууль

29. Ардчилсан нийгэм бүх иргэдэд адил тэгш боломж олгодог онцлогтой. Энэ нь хэн нэгнийг илүү харж, эрх дарх олгохгүй гэсэн үг юм. Энэ ардчиллын аль зарчим бэ? /2оноо/

А. Хууль дээдлэх зарчим      Б. Нээлттэй байх зарчим  
В. Цөөнхийг хүндэтгэх зарчим      Г. Зөвшилцлийн зарчим

30. Монгол улсын төрийн эрх мэдлийн хуваарилалтын тогтолцоог гүйцээнэ үү. /2оноо/

Хууль тогтоох

Шүүх эрх мэдэл

А. Хууль дагах



сонирхлыг тэнцвэржүүлэхэд чиглэнэ.

4. Үндэсний эрх ашигт нийцсэн байх Г. Энэ зарчим нь үндэсний язгуур ашиг сонирхлыг

сахин хамгаалсан, үндэсний хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйлчилнэ.

40. Зөв харгалзуулна уу. /4оноо/

1	Олон улсын харилцааны улс бус оролцогч	А	Бүрэн эрхт тусгаар тогтносон улс байдаг. Бүрэн эрхт улс нь НҮБ-ын гишүүн болж олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх ёстой.
2	Олон улсын харилцааны улс оролцогч	Б	Де-факто, Де-юре хоёр хэлбэрээр хүлээн зөвшөөрдөг. Олон улсын эрх зүйн ойлголтоор тухайн улсыг бүрэн бус хүлээн зөвшөөрсөн хэлбэр юм.
3	Олон улсын харицааны үндсэн оролцогч	В	Засгийн газрын оролцоо, дэмжлэггүйгээр улс үндэстэн дамнасан янд бүрийн оролцогчид, олон улсын байгууллага хоорондын харилцаа, хамтын ажиллагаа. Ашгийн төлөө бус, 2-оос дээш улсаас хандив авч, үйл ажиллагаа явуулдаг.
4	Их гүрэн	Г	Өөрийн аюулгүй байдлыг хангах төдийгүй хөрш холбоотон улсууд, бүс нутгийн аюулгүй байдлыг хангах чадалтай байдаг.

Агуулга	Б хувилбар
Нийгэм, нийгмийн харилцаа	1Б
	2Д
	3Г
	4В
	5.1А2Б3В4Г
Соёл	6В
	7А
	8В
	9Б
	10.1А2Б3В
Эрх зүй	11Г
	12А
	13В
	14В
	15Б
	16.1А2Б3В4Г
	17.1В2Г3А4Б
Эдийн засаг	18В
	19А
	20Б
	21.1А2Б3В4Г
	22В
	23.1Г2Д3А4В5Б
	24.1А2Б3Г4В
Улс төр	25Б
	26В
	27В
	28В
	29Д
	30Б
	31.1А2В3Б
	32А
	33А
Олон улсын харилцаа	34Г
	35А
	36Б
	37В
	38А
	39.1А2Б3В4Г
	40.1В2Б3А4Г